



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/394

Арвайхээр

**Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл
сонгон шалгаруулалтыг зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1.3.2, 9.17 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүсэд үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газрын зориулалттай 1 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Ц.Хашхүү (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Э.Хорлоо (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Ч.Бат-Өлзий (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газар, Байгаль орчин, Аялал жуулчлалын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Өмчийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Комиссын дарга (Т.Ариунболд)-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулахыг зохих журмын дагуу зохион байгуулах.

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100840

D:My Doc. Zahiramj. Zasag darga